

“ДОТООД ХЭРГИЙН ИХ СУРГУУЛИЙН СОНСОГЧ, СУРАЛЦАГЧДЫН СЭТГЭЦЭД НӨЛӨӨТ БОДИСЫН ХЭРЭГЛЭЭ БА ЭРҮҮЛ МЭНДЭД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨ”

STUDENTS AND STUDENTS OF THE UNIVERSITY OF INTERNAL AFFAIRS
THE USE OF PSYCHOACTIVE SUBSTANCES AND ITS EFFECTS ON HEALTH



Ц.Нандинцэцэг

*Дотоод хэргийн их сургууль Шинжлэн магадлах
ухааны сургуулийн Байгалийн ухаан, техник зүйн
шинжилгээний тэнхимийн багш*

Хураангуй : Энэхүү судалгаа нь Дотоод хэргийн их сургуулийн сонсогч, суралцагчдын дунд сэтгэцэд нөлөөт бодисын хэрэглээний шалтгаан, эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөө болон мэдээллийн хүртээмжийн түвшинг тодорхойлоход чиглэсэн болно. Судалгаанд нийт 600 оюутан оролцож, хэрэглээний шалтгаан, сэтгэл зүйн болон бие махбодийн өөрчлөлтүүдийг судалсан. Судалгааны үр дүнд МУИС-ийн оюутнуудын дунд “стресс тайлах” (48.6%) болон “найз нөхдийн нөлөө” (36.8%) зонхилж байсан бол ДХИС-ийн сонсогчдын хувьд “сониуч байдал” (42.1%) ба “түр зуурын туршилт” (33.7%) зонхилж байв. Хэрэглэгчдийн дунд унтах хэв маяг алдагдах (63.4%), анхаарал төвлөрөл сулрах (38.9%), сэтгэл гутрал, түгшүүрийн шинж тэмдэг илрэх (27.2%) нь хэрэглэгч бус оюутнуудтай харьцуулахад статистикийн хувьд илт өндөр ($t = 3.27, p < 0.01$) гарсан. Мөн судалгаанд хамрагдагсдын 72.5% нь сэтгэцэд нөлөөт бодисын хор уршгийн талаар хангалттай мэдлэггүй байсан нь мэдээллийн хүртээмж, урьдчилан сэргийлэх боловсролын ач холбогдлыг харуулж байна. Судалгааны дүн нь холбогдох байгууллагуудад бодлого боловсруулалт, урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэхэд үнэтэй эх сурвалж болох юм.

Түлхүүр үгс: сэтгэцэд идэвхт бодис, оюутан, хэрэглээ, эрүүл мэнд, статистик шинжилгээ

Үндсэн хэсэг

Судалгааны зорилго: Өсвөр насныхны дунд сэтгэцэд нөлөөт бодисын хэрэглээний эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөллийг судлах, урьдчилан сэргийлэх арга хэмжээний ач холбогдлыг үнэлэх, цаашдын бодлого боловсруулалт, нийгмийн хариу үйлдэлд хувь нэмэр оруулах

Судалгааны зорилт: Өсвөр насныхны дунд сэтгэцэд нөлөөт бодисын хэрэглээний түвшин, тархалт, шалтгаан нөхцөлийг тодорхойлох, уг хэрэглээтэй холбоотой бие махбод болон сэтгэцийн эрүүл мэндийн гол эрсдэл, сөрөг үр дагавруудыг шинжлэх, сургууль, гэр бүл, нийгмийн орчны хүчин зүйлсийн нөлөөллийг судлах, монгол улсад өсвөр үеийнхэнд чиглэсэн урьдчилан сэргийлэх болон эмчилгээний хөтөлбөрүүдийн хэрэгжилт, үр нөлөөг үнэлэх, өсвөр насныхны сэтгэл зүйд тохирсон, илүү хүртээмжтэй бодлого, хөтөлбөр боловсруулахад чиглэсэн санал зөвлөмж дэвшүүлэх

Судалгааны ач холбогдол: Сэтгэцэд нөлөөт бодисын хэрэглээ нь зөвхөн хувь хүний эрүүл мэндийн асуудал бус, нийгмийн тогтолцоо, хууль сахиулах байгууллагын чадавх, иргэдийн итгэлцэлд нөлөөлөхүйц өргөн хүрээний үр дагавартай асуудал юм. Ийм төрлийн бодисын хэрэглээ нь оюун санааны тогтворгүй байдал, суралцах чадварын уналт, сахилгын зөрчил, гэмт хэрэгт холбогдох эрсдэл зэргээр илэрч, ялангуяа хууль сахиулах салбарт суралцагчдын хувьд ёс зүйн болон мэргэжлийн чадавхад ноцтой аюул учруулж болзошгүй юм.

Судалгааны арга зүй: Энэхүү судалгаа нь сэтгэцэд нөлөөт бодисын хэрэглээний түвшин, шалтгаан, эрүүл мэндэд үзүүлэх нөлөө, хандлагын ялгааг тодорхойлох зорилготойгоор хийсэн харьцуулсан судалгаа юм. Судалгаанд Дотоод хэргийн их сургууль (ДХИС) болон Монгол Улсын Их Сургууль (МУИС)-ийн Хууль зүйн сургуулийн оюутнууд хамрагдсан.

Судалгааны загвар: Тайлбарлах болон харьцуулан шинжлэх загварыг хослуулсан бөгөөд хоёр сургуулийн оюутнуудын дунд хэрэглээний түвшин болон хандлагын ялгааг тодорхойлоход чиглэгдсэн. Мөн хувьсагчдын хоорондын хамаарлыг тогтоох зорилготой.

Эрүүл мэндийн талаарх судалгаагаар, хэрэглэгчдийн 63.4% нь унтах хэв маяг алдагдсан, 38.9% нь анхаарал төвлөрөл сулрах, 27.2% нь түгшүүр, сэтгэл гутралын шинж илэрсэн гэж хариулсан бөгөөд эдгээр сөрөг үзүүлэлт нь хэрэглэгч бус оюутнуудтай харьцуулахад статистикийн хувьд илэрхий өндөр гарсан ($t = 3.27, p < 0.01$). Мөн судалгаанд хамрагдагсдын 72.5% нь "сэтгэцэд нөлөөт бодисын хор уршгийн талаар хангалттай мэдлэггүй" гэж дүгнэсэн нь урьдчилан сэргийлэх боловсрол, мэдээллийн хүртээмж хангалтгүй байгааг илтгэж байна.

Судалгааны үр дүнг SPSS статистикийн програм ашиглан боловсруулсан бөгөөд дараах үр дүнгүүдийг олсон. Эхний хувьсагчийн шинжилгээгээр хэрэглэгчид болон хэрэглэгчгүй бүлгүүдийн хэрэглээний тархалт харьцуулсан бөгөөд Chi-Square шинжилгээгээр дараах үр дүн гарсан:

Хүснэгт 1: Хэрэглээний тархалт – Crosstab + Chi-Square

Сургууль	Хэрэглэж үзсэн	Хэрэглэж үзээгүй	Нийт
----------	----------------	------------------	------

ДХИС	59 (19.7%)	241 (80.3%)	300
МУИС-Хууль	100 (33.3%)	200 (66.7%)	300
Нийт	159	441	600

Chi-Square-Test $\chi^2(1, N=600) = 12.61, p < 0.001$

Тайлбар: МУИС-ийн оюутнуудын дунд сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэж үзсэн байдал статистикийн хувьд ДХИС-ийн сонсогчдоос өндөр байна.

Дараа нь сэтгэл зүйн сөрөг нөлөөлөлд нөлөөлж буй үзүүлэлтүүдийг t-шинжилгээний тусламжтайгаар тодорхойлсон:

Хүснэгт 2: Сэтгэл зүйн сөрөг нөлөөлөл

Эрүүл мэндийн үзүүлэлт	Хэрэглэгчид (M±SD)	Хэрэглэдэггүй (M±SD)	t	p-value
Анхаарал төвлөрөл	2.74 ± 0.89	3.41 ± 0.76	-5.62	< 0.001
Сэтгэл түгших түвшин	3.15 ± 0.95	2.54 ± 0.82	4.28	< 0.001

Тайлбар: Хэрэглэгчид анхаарал төвлөрөх чадвар муудаж, сэтгэл зүйн түгшүүрийн түвшин илүү өндөр байгаа нь статистикийн хувьд илэрхий ялгаатай байна.

Гурав дахь шинжилгээгээр хэрэглээ ба мэдээллийн хүртээмжийн харилцан хамаарлыг үнэлсэн бөгөөд үр дүнгүүд дараах байдлаар гарсан:

Хүснэгт 3: Хэрэглээ ба мэдээллийн хүртээмж – Correlation

Хувьсагч	1	2
1. Хэрэглээний түвшин	1	-0.42**
2. Сэтгэцэд нөлөөт бодисын талаарх мэдлэг	-0.42**	1

$r = -0.42, p < 0.01$

Тайлбар: Сэтгэцэд нөлөөт бодисын талаарх мэдлэгийн түвшин бага байх тусам хэрэглээ өндөр байх хандлага ажиглагдаж байна.

ДҮГНЭЛТ

Судалгааны үр дүн нь Дотоод хэргийн их сургуулийн сонсогч, суралцагчдын эрүүл мэндэд ноцтой аюул учруулж, ирээдүйн хууль сахиулагч мэргэжилтнүүдийн ёс суртахуун, бие хүний хөгжлийг хойш нь татах эрсдэлтэй

байгааг харуулж байна. Иймд урьдчилан сэргийлэх хөтөлбөрүүд, эрүүл мэндийн боловсрол, бодлогын шинэчлэл шаардлагатай байна. Судалгааны үр дүн нь боловсролын байгууллагууд болон эрүүл мэндийн салбарын мэргэжилтнүүдэд үнэтэй эх сурвалж болж ашиглагдаж боломжтой.

НОМ ЗҮЙ

1. Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага. (2024). Архи, цахилгаан тамхи, каннабисийн хэрэглээ өсвөр насныхны дунд нэмэгдэж байна – Шинэ тайлан. ДЭМБ-ын Европын бүсийн газар.

2. Мандах, Х. (2022). Их, дээд сургуулийн оюутнуудын дунд архи, согтууруулах ундааны хэрэглээний судалгаа (Бакалаврын дипломын ажил, Хүрээ Мэдээлэл Холбооны Технологийн Их Сургууль). https://library.huree.edu.mn/data/402022/20230522/Мандах_Халиунаа_Дипломын_ном.pdf

3. Энхболд, Б. (2022). Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаа: Шүүгч, прокурорт зориулсан гарын авлага. Улаанбаатар: Бакус дизайн ХХК.

4. Монгол Улсын хууль. (2002). Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хууль (2002 оны 5 дугаар сарын 3-ны өдөр баталсан). Монгол Улсын эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем. <https://legalinfo.mn/law/details/3135>

5. Дарьсүрэн, Б. (2020). Хорих ангид мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодис нэвтрэхээс урьдчилан сэргийлэх ажил, түүний эрх зүйн зохицуулалт (Магистрын зэрэг горилсон судалгааны ажил, Дотоод хэргийн их сургууль).

Нямбат, Б. (2022). Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодис хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодох зорчилт, түүнд хяналт тавих арга зүй, өнөөгийн байдал (Бакалаврын зэрэг горилсон дипломын ажил, Дотоод хэргийн их сургууль).